

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: **2015-06-29**

Тендер шалгаруулалтын нэр: **МУИС-ийн Оюутны 3-р байрны их засвар**

Тендер шалгаруулалтын дугаар: **НТ-15/22**

Монгол Улсын Их Сургууль нь эрх бүхий тендерт оролцогчдоос **МУИС-ийн Оюутны 3-р байрны их засвар** гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (**хүсвэл нэмэлт хувийг**) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь **100000** төгрөгөөр худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **2013, 2014 оны аль нэг жилд гүйцэтгэсэн ажлын борлуулалтын хэмжээ нь ирүүлж буй үнийн саналын мөнгөн дүнгээс багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Санал болгож байгаа үнийн дүнгийн 50%-с багагүй байна**

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **2013, 2014 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг нотариатаар баталгаажуулсан хувь /тодруулгын хамт/, 2015 оны эхний улирлын татварын албанд хянагдсан санхүүгийн тайлан**

Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: **2013, 2014 онуудад хэрэгжүүлсэн ижил төстэй ажил нь үнийн саналын 70 хувиас багагүй байна.**

Тендерийн хамт **6,057,954** төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2015 оны 7-р сарын 29** ний өдрийн **10** цаг **00** минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2015 оны 7-р сарын 29** -ний өдрийн, **10** цаг **30** минутад нээнэ.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.

Дотоодын давуу эрхийн зөрүү тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Их сургуулийн гудамж 1, МУИС, Хангамж Үйлчилгээний Хэлтэс, Хичээлийн 1-р байр 213, 204 тоот, утас 321290, 321546